




© Г.Бэрэл

# БАГАНУУР ДҮҮРЭГ

**“Хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн ба хэрэгцээ шаардлага”  
Түргэвчилсэн судалгаа**

**2022 оны 9 дүгээр сараас 2023 оны 2 дугаар сар  
(Гурав дугаар ээлжийн тоон мэдээлэл нэгтгэл)**



Swiss Agency for Development  
and Cooperation SDC  
Швейцарын хөгжлийн агентлаг

## АГУУЛГА

---

|   |    |
|---|----|
| Удиртгал ба аргачлал.....                                       | 1  |
| 1. Мэдээллийн дүн шинжилгээ – Багануур дүүрэг.....              | 3  |
| 1.1 Хүн амын суурь тоон үзүүлэлт ба хүн ам зүйн тойм.....       | 3  |
| 1.2 Бүртгэл.....  | 4  |
| 1.3 Ирсэн иргэд.....  | 5  |
| 1.4 Явсан иргэд.....  | 7  |
| 1.5 Хөдөлмөр эрхлэлт.....                                       | 9  |
| 1.6 Санхүүгийн нөхцөл байдал.....                               | 9  |
| 1.7 Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлууд..... | 9  |
| 1.8 Үйлчилгээний хүртээмж ба дэд бүтэц.....                     | 11 |
| Дүгнэлт.....  | 13 |

# УДИРТГАЛ БА АРГАЧЛАЛ

## УДИРТГАЛ

Энэхүү дүүргийн хэмжээний тайлан нь Багануур дүүргийн хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн ба хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход чиглэсэн үндсэн сэдвүүдийн хүрээнд 2022 оны 9 дүгээр сараас 2023 оны 2 дугаар сарын тойм мэдээллийг харуулсан болно. Уг судалгаа нь Монгол дахь ОУШХБ-аас Улаанбаатар хотод хийсэн хөдөлгөөнийг тандах ДТМ судалгааны аргачлалын гурав дахь удаагийн тоон мэдээлэл нэгтгэлийн үе шат юм.

Нэгдүгээр шатны тоон мэдээлэл нэгтгэлийн адил энэхүү судалгаагаар Багануур дүүргийн хэмжээнд хүн амын бодит тоон мэдээлэл, суурь тоон үзүүлэлт, шилжин ирэгсэд ба явагсад (шилжилт хөдөлгөөн), хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн нөхцөл байдал, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлууд, үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц гэсэн найман үндсэн сэдвийг авч үзсэн болно. Тоон мэдээллийг Багануур дүүргийн хамгийн жижиг засаг захиргааны нэгж болох хэсгийн<sup>1</sup> нутаг дэвсгэрийн нөхцөл байдал, мэдээлэл нэгтгэгчийн мэдлэгийн нөөц бололцоо, мэдээллийн нээлттэй байдлаас хамааран хэсгийн ахлагч нараар тандалт судалгаа, ярилцлага хийх замаар нэгтгэсэн болно.

Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (ОУШХБ)-ын өмнөх судалгаануудаас харахад газрын доройтол, уур амьсгалын өөрчлөлт зэрэг хүчин зүйлс Монгол Улсын уламжлалт амьдралын хэв маягийг өөрчилж байгааг бидний хийсэн өмнөх судалгаанууд тогтоосоор байна. Ган, зудын<sup>2</sup> давтамж нэмэгдэж, ажлын байр цөөн, амьдрах орчин нөхцөл хангалтгүй, хөдөөгийн хүн амын мал аж ахуйгаас хараат байдал зэрэг нь суурин газар болон бусад аймаг<sup>3</sup> орон нутаг руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлэх хүчин зүйл болсоор байна.

Тэдгээр шилжих хөдөлгөөний үндсэн шинж чанарыг ойлгоход Монгол Улсын хэмжээнд

өөр өөр байршилд ажиллаж амьдарч, шилжилт хөдөлгөөнд оролцож буй хүн амын бодит тоон мэдээлэл шаардагдах бөгөөд мэдээллийн зөрүүтэй байдал үндсэн шинж чанарыг ойлгоход саад болж байна. Энэхүү судалгаа нь Багануур дүүргийн хүн ам, шилжилт хөдөлгөөний бодит мэдээллийг олж авах замаар энэ хоёр мэдээлэл хоорондын зөрүүг арилгаж дотоодын шилжилт хөдөлгөөний талаарх бодлого, үйл ажиллагааг бодит мэдээллээр хангах, мэдээллийн баазыг нэмэгдүүлэх зорилготой.

## СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

Энэхүү тайланд Монгол Улс дахь ОУШХБ-ын Шилжилт хөдөлгөөнийг тандах матриц (ДТМ)-ийн аргыг үндэслэн боловсруулсан хөдөлгөөнийг тандах (МТ) дэд аргачлалыг ашигласан болно.

Судалгаанд Багануур дүүргийн хамгийн жижиг засаг захиргааны нэгж болох хэсгийн түвшинд хэсгийн ахлагч нараар дамжуулан тоон мэдээллийг нэгтгэсэн. Хэсгийн ахлагч нар өөрийн нутаг дэвсгэрийн иргэдтэй ярилцах, ажиглалт хийх, өөрсдийн бусад нөөц бололцоог ашиглах болон харилцаа холбооны хэрэгслүүдийг ашиглан тоон мэдээллийг нягтлах, баталгаажуулах ажлыг хийсэн. Хэсгийн ахлагч нарыг судалгааны агуулга тус бүрээр нь ялган эрэмбэлсэн найман үндсэн сэдвийг багтаасан судалгааны агуулгыг/хэрэгслийг нөхөхийг хүссэн юм. Тэд Кобо программ хангамжаар дамжуулан тоон ажиглалт, баталгаажуулалт хийгдсэн мэдээллийг гар утас эсвэл таблет ашиглан цахим системд нөхөж илгээсэн. Мэдээллийг зөв, чанартай нэгтгэхийн тулд судалгааг хэрэгжүүлэхээс өмнө хэсгийн ахлагч нарыг судалгааны асуулгын дэлгэрэнгүйг ойлгох, тандалт судалгааг хийх арга аргачлалыг багтаасан сургалтад хамруулсан. Түүнчлэн ДТМ судалгааг хариуцсан ажилтнууд мэдээлэл нэгтгэх явцад үүссэн аливаа асуулт, асуудалд цаг тухайд нь хариу өгч бэлэн байдалд ажилласан юм.

1 Хэсэг гэдэг нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хамгийн жижиг засаг захиргааны нэгж юм.

2 Зуд гэдэг нь зуны дэлгэр цагт бороо хур дутмаг, тариа ногоо ургац муутай гандуу байсантай холбогдуулан өвөл өвс тэжээл дутагдах, мал идэх өвсгүй болж өвөлжилт хүндрэхийг хэлнэ.

3 Аймаг нь Монгол Улсын хөдөө орон нутгийн засаг захиргааны анхдагч нэгж хэлнэ.

Өгөгдлийг системд нэгтгэх үйл явц албан ёсоор хаагдамагц ДТМ-ийн судалгааны баг бүрэлдэхүүн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажлыг эхлүүлсэн бөгөөд гарч болзошгүй алдаа, тоон мэдээллийн зөрүү, давхардал зэргийг илрүүлэхийн тулд өгөгдлийн хяналтын шатанд чанарын баталгаажуулалтын шалгалтыг сонгогдсон дүүргүүд дээр хийсэн. Энэхүү тайланд тусгагдсан аливаа үр дүнг хэсгийн түвшинд нягтлан харах боломжтой гэдгийг дурдах нь зүйтэй юм.

## ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙДАЛ


Энэхүү судалгаанд ашигласан аргачлал нь үндсэн мэдээлэгч нараас өгсөн мэдээлэлд дүн шинжилгээ хийж байгаа төдийгүй бусад эх сурвалжтай гурвалсан өгөгдлийн санг бий болгох үндсэн зорилготой юм.

Нэгтгэсэн өгөгдөл нь үндсэн мэдээлэгч нарын мэдлэгт тулгуурласан ажиглалт, тооцоолол, төсөөллийг илэрхийлдгээрээ ялгаатай юм. Тиймээс өгөгдлийн найдвартай байдал нь ажиглалт, тандалт судалгааг хийж буй нэгжийн хэмжээ (жишээ нь, хэсгийн хэмжээ, хүн ам), хэсгийн ахлагчийн иргэдтэй хэр ойр холбоотой, ажиглалт, тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадвар, мэдлэг гэх мэт хүчин зүйлсээс хамаарч ялгаатай байх магадлалтай тул өгөгдлийн гадаад болон дотоод мэдээллийн хүчин төгөлдөр байдал хязгаарлагдмал юм.

Нэмж дурдахад, тоон мэдээллийн үр дүнгийн гурвалжинд тусгасан үнэлгээ нь тухайн ажиглалт хийсэн байршилд зөвхөн нэг гол мэдээлэгчээс авсан мэдээллээр хязгаарлагдсан болно.

## ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Газрын зураг 1. Багануур дүүргийн газрын зураг (хороогоор<sup>4</sup>)



<sup>4</sup> Хороо гэдэг нь Улаанбаатар хотын засаг захиргааны нэгж юм.

**Хүснэгт 1. Тоон мэдээлэл нэгтгэх үеийн Багануур дүүргийн хүн ам**

| Дүүрэг   | Хэсгийн тоо | Хүн амын тоо<br>(бүртгэлгүй түр оршин суугчдын мэдээллийг багтаасан) |
|----------|-------------|--|
| Багануур | 34          | 27,105   |
| Нийт     | 34          | 27,105   |

## НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

**Хүн амын суурь тоон үзүүлэлт:** Гарал үүсэл, бичиг баримтын байдал, хууль эрх зүйн нөхцөл байдал, бүртгэл, нас, хүйс, нийгэм-хүн ам зүйн бусад шинж чанараас үл хамааран үнэлгээ хийх үед тухайн байршилд байгаа бүх оршин суугч.

**Өрх:** Нэг дээвэр дор амьдардаг, зардал болон хоол хүнсээ хуваалцдаг бүлэг хүмүүс.

**Ирсэн иргэд:** Улаанбаатар хот дотор эсвэл хотын гаднаас ирсэн эсэхээс үл хамааран хамгийн багадаа дөрвөн долоо хоног болон түүнээс дээш хугацаагаар оршин суух зорилготой хотын ямар нэг байршилд ирсэн хүмүүс (шилжилт хөдөлгөөн, түр оршин суух бүртгэл зэргийг хийлгэсэн эсэхээс үл хамаарна).

**Явсан иргэд:** Улаанбаатар хот дотор эсвэл хотын гадагшаа явсан эсэхээс үл хамааран хамгийн багадаа

дөрвөн долоо хоногийн туршид буцах бодолгүй, аль нэг байршилд явсан хүмүүс (шилжилт хөдөлгөөн, түр оршин суух бүртгэл зэргийг хийлгэсэн эсэхээс үл хамаарна).

**Мэдээлэгч:** Мэдээллийн эх сурвалж бөгөөд энэ судалгаанд Улаанбаатар хотын нийт хэсгийн ахлагч нарыг хэлнэ.

**Мэдээлэл нэгтгэгч:** Мэдээлэл нэгтгэж буй хүн. Энэхүү үнэлгээнд үндсэн мэдээлэгч нар мэдээлэл нэгтгэсэн тул эдгээр хоёр нэр томьёо давхцана.

**Гэр хороолол болон орон сууц зонхилсон хэсэг:** Засаг захиргааны хамгийн жижиг хэсэгт улсаас халаалт, цэвэр усаар хангагдсан орон сууц, зөөврийн усаар хэрэгцээгээ хангадаг, мод, нүүрс түлж гэрээ дулаацуулдаг гэр хороолол зэрэгцэн оршдог хэсгийг хэлнэ.

# 1. МЭДЭЭЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

## 1.1 ХҮН АМЫН СУУРЬ ТООН ҮЗҮҮЛЭЛТ БА ХҮН АМ ЗҮЙН ТОЙМ



**8,101**

Өрх



**27,105**

Хувь хүн



**53%**

Эмэгтэй



**34%**

Хүүхэд



**838**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн



**165**

Асран хамгаалагчгүй ахмад настан



**173**

Жирэмсэн эмэгтэй



**395**

Эцэг, эхийнхээ аль нэгээс тусгаарлагдсан хүүхэд



**566**


Өрх толгойлсон эцэг, эхтэй өрх



**1,489**

60 ба түүнээс дээш насны өрхийн тэргүүлэгчтэй өрх

График 1. Хүн ам зүй (ээлэх хувь, насны бүлгээр)




Үнэлгээ хийх үед Багануур дүүрэгт 27,105 иргэн буюу 8,101 өрх бүртгэгдсэн нь Улаанбаатар хотын хүн амын 2 хувийг эзэлж байна. Дүүргийн хүн амын 53 хувь нь эмэгтэй байна. 34 хувь нь насанд хүрээгүй хүүхэд байгаа нь өндөр үзүүлэлт бөгөөд үүний 10 хувийг 0-5 нас, 24 хувийг 6-17 насны хүүхдүүд эзэлж байна. Хүн амын 56 хувийг 18-59 насны насанд хүрэгчид, 10 хувийг 60 болон түүнээс дээш насны ахмад настан эзэлж байна.

Багануур дүүрэгт нийт дээ 838 хөгжлийн бэрхшээлтэй иргэн (дүүргийн хүн амын 3 хувь), 173 эмэгтэй жирэмсэн (эмэгтэйчүүдийн 1 хувь), 165 асран хамгаалагчгүй ахмад настан (60 болон түүнээс дээш настай өндөр настны 12 хувь), 397 эцэг, эхийнхээ аль нэгээс эсвэл аль алинаас тусгаарлагдсан хүүхэд (18-аас доош насны хүүхдүүдийн 4 хувь) судалгаа хийсэн хугацаанд бүртгэгдсэн байна. Түүнчлэн 566 өрх толгойлсон эцэг, эхтэй өрх, 60 ба түүнээс дээш

насны өрхийн тэргүүлэгчтэй<sup>5</sup> 1,489 өрх байгаа нь тус дүүргийн нийт өрхийн 7 хувь болон 18 хувийг тус тус эзэлж байна.

Багануур дүүрэг нь нийт 5 хороо, 34 хэсэгтэй. 1 дүгээр хороо хамгийн их хүн амтай буюу дүүргийн хүн амын 32 хувийг эзэлж байгаа бол үүний дараа 3 дугаар хороо нийт хүн амын 29 хувийг түс бүр эзэлж байна.

График 2. Хүн ам зүй, хороогоор (ээлэх хувь)



## 1.2 БҮРТГЭЛ


Судалгааг нэгтгэсэн хугацаанд Багануур дүүргийн нийт хэсгүүдийн 47 хувь нь иргэдийн 90 гаруй хувь нь оршин суугчийн бүртгэлтэй (шилжилт хөдөлгөөний бичиг баримтын зөрчилгүй) гэсэн тооцоо гаргасан. Түүнчлэн хэсгүүдийн 38 хувь нь

дийлэнх иргэд нь бүртгэлтэй (иргэдийн 61-89 хувь), 12 хувь нь тал нь бүртгэлтэй (иргэдийн 40-60 хувь) гэсэн бол үлдсэн хэсгийн ердөө 3 хувь нь иргэдийн 40-с доош хувь бүртгүүлсэн гэж мэдээлжээ.

График 3. Оршин суух бүртгэл (хэсэгт эзлэх хувь)



График 4. Оршин суух бүртгэл 90-с дээш хувь хийгдсэн хороод (нийт хэсэг)



Иргэд өөрсдийгөө тухайн хэсэгт түр зуур оршин сууж байгаа гэж үзэн өөрийн оршин суугаа газартаа бүртгүүлэхгүй байгаа нь бүртгэлгүй байх үндсэн шалтгаан болж байна гэж тус дүүрэг дэх бүх хэсгийн 28 хувь мэдээлсэн. Энэ үзэгдэл ялангуяа 1 дүгээр хороонд (8 хэсгийн мэдээлснээр) зонхилон тохиолдсон харагдаж байна.

Бүртгүүлэхгүй байх бусад шалтгаанд бүртгэлийн маягыг бөглөхөд төвөгтэй (15 хувь), бүртгэлийн маягыг хэрхэн бөглөхийг мэдэхгүй (12 хувь), бүртгүүлэхэд хэт их мэдээлэл шаарддаг (11 хувь), боловсрол (10 хувь) гэсэн шалтгаанууд багтжээ.

<sup>5</sup> Өрхийн тэргүүн нь 60 ба түүнээс дээш насны хүнтэй өрх

График 5. Бүртгэл хийлгэхгүй байгаа үндсэн шалтгаан (эзлэх хувь)





График 6. Түр зуур оршин сууж байгаа гэж үзэн бүртгэл хийлгэхгүй байгаа иргэдийн хамгийн өндөр үзүүлэлттэй хороод (хэсгүүдийн эзлэх хувь)



### 1.3 ИРСЭН ИРГЭД<sup>6</sup>

Судалгаа явуулахаас өмнөх сүүлийн зургаан сарын хугацаанд Багануур дүүрэгт нийт 716 иргэн ирсэн нь Улаанбаатар хотод ирсэн нийт иргэдийн 2 хувийг эзэлж байна. 3-р хороонд (дүүрэгт нийт ирэгсдийн 42 хувь) хамгийн өндөр хувьтай ирсэн иргэд бүртгэгдсэн гэж мэдээлсэн. Тус дүүргийн өөр хороо/хэсгээс ирэгсэд 57 хувьтай зонхилж байгаа бол Улаанбаатар хотын бусад дүүргээс ирэгсэд 7

хувь, хөдөө орон нутгаас ирэгсэд (3 хувь) байна.

Улаанбаатар хотын бусад дүүргээс ирэгсдийн 50 хувь нь гэр хороолол зонхилсон хэсгүүдээс ирсэн бол 36 хувь нь орон сууц зонхилсон хэсгүүдээс, 14 хувь нь орон сууц, гэр хороолол холимог хэсгүүдээс ирсэн байна.<sup>7</sup> Хөдөө орон нутгаас ирсэн иргэдийн 50 хувь нь аймгийн төвийн багуудаас, 25 хувь нь сумын төвийн багуудаас<sup>8</sup> ирсэн байна.


<sup>6</sup> Ирсэн иргэд гэдэг нь тус дүүрэгт эсвэл дүүргээс гадна байршлаас ирсэн эсэхээс үл хамааран тус дүүрэг дэх аль нэг байршилд оршин суухаар ирсэн иргэн, айл өрхийг хэлнэ.

<sup>7</sup> Гэр хороолол зонхилсон хэсэг гэдэг нь хот төлөвлөлтийн дэд бүтэц болон усны хангамжгүй Монголын уламжлалт амьдрах байрыг хэлнэ. Гэр хороолол зонхилсон хэсгийн оршин суугчид ихэвчлэн зөөврийн ус ашиглаж мод эсвэл нүүрс түлж халаалтаа авдаг. Орон сууц зонхилсон хэсэгт улсаас халаалт болон ус хангамжийг шийдэж өгсөн байдаг. Гэр хороолол ба орон сууц холимог хэсэгт эдгээр хоёр амьдрах орчин нь хамтран оршдог.


<sup>8</sup> Баг гэдэг нь хөдөө орон нутаг дахь засаг захиргааны хамгийн жижиг нэгж юм. Аймгийн төвийн баг гэдэг нь аймгийн төвд байрладаг засаг захиргааны хамгийн жижиг нэгж бол сумын төвийн баг гэж Монгол Улсын хөдөө орон нутгийн засаг захиргааны хамгийн жижиг хоёр дахь нэгжийг хэлнэ.




**График 7. Ирсэн хөдөлгөөн хамгийн их бүртгэгдсэн 5 хороо (эзлэх хувь)**




**Бүдүүвч 1. Ирсэн хөдөлгөөний төрөл (эзлэх хувь)**



**Бүдүүвч 2. Улаанбаатар хот доторх ирсэн хөдөлгөөний төрөл (орон байрны төрөл)**




**Бүдүүвч 3. Хөдөө орон нутгаас ирсэн хөдөлгөөний төрөл (эзлэх хувь)**




Үнэлгээ хийх үед буюу 2023 оны 1, 2, 3-р саруудад Багануур дүүрэгт 8 иргэн отор нүүдэл<sup>9</sup> хийх зорилгоор иржээ. 4-р хороонд энэ газар нутагт бэлчээрийг гарц илүү сайн гэсэн шалтгаанаар хамгийн олон иргэн ирсэн бол (63 хувь) 1 дүгээр

хороонд улирлын шилжилт хөдөлгөөнд оролцох гэсэн шалтгаантай ирэгсэд 25 хувь, 2 дугаар хороонд явсан газар нутаг бэчээр гарц байхгүй тул энэ газарт оторлох шалтгаанаар ирсэн гэж мэдээлсэн иргэд 13 хувийг эзэлжээ.

**Бүдүүвч 4. Отор нүүдлийн үндсэн шалтгаан (эзлэх хувь)**




**График 9. Оторлох зорилгоор хамгийн олон иргэд ирсэн хороод (дүүрэгт эзлэх хувь)**



<sup>9</sup> Отор нь хол газар удаан хугацаагаар малаа маллан нүүдэллэхийг хэлнэ.

Багануур дүүрэгт отор нүүдэл хийжээс өөр шалтгаанаар ирэгсдийн хувьд боловсрол (22хувийн мэдээлснээр) үндсэн шалтгаан хэвээр байгаа бол араас нь эрүүл мэнд (18 хувь), хөдөлмөр эрхлэлт (16 хувь) бүртгэгдсэн байна. Энэхүү үр дүнг өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулж үзэх нь зүйтэй.

**График 8. Отор нүүдлийн бус шилжилт хөдөлгөөнд оролцох болсон үндсэн шалтгаан (эзлэх хувь)**



Түүнчлэн тус дүүрэгт хөдөлмөр эрхлэх зорилгоор ирэгсдийн хувьд хөдөлмөр эрхлэлтийн зонхилох салбар нь уул уурхайн олборлолтын салбар (36 хувь), нийгмийн ажлын салбар (21 хувь) болон өрхийн ажлын салбар (21 хувь) байжээ.

**График 9. Хөдөлмөр эрхлэх үндсэн шалтгаанаар ирэгсдийн хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбарууд (эзлэх хувь)**




### 1.4 ЯВСАН ИРГЭД<sup>10</sup>

Тоон мэдээлэл нэгтгэх судалгааны гурав дугаар үе шат эхлэхээс өмнөх зургаан сарын хугацаанд Багануур дүүргээс нийт 447 иргэн явсан гэж бүртгэгдсэн ба энэ үзүүлэлт нь Улаанбаатар хотоос явсан нийт иргэдийн 2 хувийг эзэлж байна. Явсан иргэдийн хамгийн өндөр хувийг 3-р хороо (дүүргийн нийт явсан иргэдийн 52 хувь) эзэлжээ. Улаанбаатар хотын бусад дүүрэг рүү явсан иргэдийн үзүүлэлт (61 хувь) өндөр байгаа бол дүүрэг дотроо бусад хороо/хэсэг


рүү (36 хувь), хөдөө орон нутаг руу (3 хувь) явсан хөдөлгөөн мөн бүртгэгдсэн байна.

Улаанбаатар хот дотроо шилжин явагсдын гуравны нэг нь орон сууц зонхилсон хэсгүүд рүү, гуравны нэг нь гэр хороолол зонхилсон хэсгүүд рүү, үлдсэн хувь нь орон сууц, гэр хороолол холимог хэсгүүд рүү нүүсэн байна. Түүнчлэн хөдөө орон нутгийг зорьсон бүх иргэд хөдөөгийн багууд рүү явсан байна.

**График 10. Явсан хөдөлгөөн хамгийн их бүртгэгдсэн хороод (эзлэх хувь)**




**Бүдүүвч 5. Хөдөө орон нутагруу явсан хөдөлгөөн (эзлэх хувь)**




<sup>10</sup> Явсан иргэд гэдэг нь Улаанбаатар хотын аль байршлыг орхиж явнаас үл хамааран хотын нэг цэгээс нөгөө цэг рүү, эсвэл орон нутаг, гадаад улс оронд явсан иргэд, айл өрхийг хэлнэ. Мөн түүнчлэн энэхүү тоон мэдээлэл нь хэсгийн ахлагчийн мэдлэг, тандалт судалгаан дээр үндэслэн тооцоолсон тоо тул бодит тоон мэдээллээс зөрүүтэй байх боломжтой юм.

**Бүдүүвч 6. Явсан хөдөлгөөний төрөл (эзлэх хувь)**



**Бүдүүвч 7. Хөдөө орон нутаг руу явсан хөдөлгөөний төрөл (эзлэх хувь)**



**График 11. Явсан хөдөлгөөний үндсэн шалтгаан (эзлэх хувь)**



Багануур дүүргээс явсан иргэдийн үндсэн шалтгаан нь боловсрол болон хөдөлмөр эрхлэлт гэж нийт хэсгүүдийн 20 хувь мэдээлсэн бол дараа нь эрүүл мэнд (16 хувь), гэр бүл (13 хувь) гэсэн шалтгаанууд бүртгэгджээ. Өмнөх судалгааны үед нийт явагсдын 18 хувьд зонхилж байсан орон сууц, газар эзэмших гэсэн шалтгаан нь энэ удаа бага зэрэг буурч 11 хувь болсон байна.

## 1.5 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ


**График 12. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбарууд (эзлэх хувь)**



Багануур дүүргийн хэмжээнд хэсгүүдийн 29 хувийн мэдээлснээр уул уурхайн олборлолтын салбар хөдөлмөр эрхлэлтийн зонхилох салбар байв. Түүнчлэн өмнөх үнэлгээгээр хэсгүүдийн 6 хувьд тус бүр зонхилж байсан төрийн захиргаа ба батлан хамгаалахын салбар болон өрхийн ажлын салбар энэ удаагийн үнэлгээгээр 18 болон 15 хувь хүрч зонхилох салбаруудаар бүртгэгджээ.

## 1.6 САНХҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

**Бүдүүвч 8. Орлогын үндсэн эх үүсвэр (эзлэх хувь)**



Багануур дүүргийн орлогын үндсэн эх үүсвэр нь хөдөлмөр эрхлэлт гэж мэдээлсэн ба энэ үзүүлэлт хэсгүүдийн 79 хувьд зонхилж байна. Үлдсэн 21 хувь нь тэтгэврийг орлогын үндсэн эх үүсвэр гэж нэрлэсэн байна.

Сүүлийн зургаан сарын хугацаанд хүнсний хэрэглээ мэдэгдэхүйц хэмжээгээр буурсан гэж хэсгүүдийн 85 хувь мэдээлжээ (өмнөх үнэлгээний 81 хувь гэсэн үзүүлэлтээс бага зэрэг өссөн). Түүнчлэн 3 хэсэгт (хэсгүүдийн 9 хувь) хүнсний хэрэглээ тогтмол байдлаар буурсан үзүүлэлттэй байсан ба энэ нь 400 иргэнд (дүүргийн хүн амын 1 хувь) хүрч нөлөөлсөн гэж үзэж байна. 2 дугаар хорооны 3 хэсэгт энэ үзүүлэлт хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа бол эдгээр хэсгүүд бүгд орлогын үндсэн эх үүсвэрийг тэтгэвэр гэж мэдээлсэн байна.

**График 13. Хүнсний хэрэглээгээ багасгасан (эзлэх хувь)**



**Хүснэгт 2. Хүнсний хэрэглээгээ багасгасан (эзлэх хувь)**

|           |
|-----------|
| 2-р хороо |
| 2-р хэсэг |
| 3-р хэсэг |
| 4-р хэсэг |

## 1.7 ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНТЭЙ ХОЛБООТОЙ ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДЛУУД

Багануур дүүргийн хэмжээнд нийт хэсгүүдийн 73 хувь тус дүүрэгт шилжин ирж буй иргэдийн нөлөөллөөс улбаатай хамгийн ихээр тулгамдаж буй багадаа нэг төрлийн асуудал байгаа гэж мэдээлсэн байна. Дүүрэгт шилжин ирэхэд хамгийн ихээр тулгамдаж буй асуудлаар агаарын бохирдлыг хэсгүүдийн 28 хувь мэдээлсэн бол үүний дараа замын хөдөлгөөнийг хэсгүүдийн 25 хувь мэдээлжээ. Энэ хоёр сорилт нь өмнөх удаагийн үнэлгээгээр 20 ба 13 хувь гэсэн үзүүлэлттэй байжээ. Нөгөөтээгүүр эрүүл мэндийн үйлчилгээний ачаалал (27 хувиас 17 хувь) болон боловсролын үйлчилгээний ачааллыг (20 хувиас 8 хувь) нэрлэсэн тулгамдсан асуудал нь өмнөх үнэлгээнээс хойш буурсан гэж бүртгэгдсэн байна.

**Бүдүүвч 9. Шижилт хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлуудыг мэдээлсэн хэсгүүд (эзлэх хувь)**




График 14. Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлууд (эзлэх хувь)



Хүснэгт 3. Агаарын бохирдлыг хамгийн ихээр мэдээлсэн хороод

Нийт  
10 хэсэг

1-р хороо  
7 хэсэг

5-р хороо  
3 хэсэг

Багануур дүүргийн хэмжээнд нийт хэсгүүдийн 64 хувь нь засаг захиргааны нэгжээс шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авч ажилласан гэж мэдээлсэн бол 36 хувь нь хангалттай арга хэмжээ авч ажиллаагүй гэж мэдээлжээ. Засаг захиргаанаас одоогийн байдлаар авч хэрэгжүүлж

буй арга хэмжээнүүдээс гадна богино хугацааны хөдөлгөөнийг бүртгэх эрх зүйн орчныг сайжруулах асуудлыг эрх баригчид анхаарах нь зүйтэй гэж үндсэн мэдээлэгчдийн дийлэнх буюу 47 хувь үзсэн бол төвлөрсөн бүсийн орох, гарах хөдөлгөөний хяналтыг сайжруулах гэж 35 хувь нь үзжээ.

Бүдүүвч 10. Засаг захирнааны нэгжээс арга хэмжээ авч байгаа эсэх (эзлэх хувь)





График 15. Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх бусад арга хэмжээ (эзлэх хувь)




## 1.8 ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ БА ДЭД БҮТЭЦ

Багануур дүүргийн хэмжээнд иргэдэд хамгийн хүртээмжгүй байгаа дэд бүтцээр орлогоо нэмэгдүүлэх боломж бололцооны дутмаг байдлыг хэсгүүдийн 28 хувь нь мэдээлсэн ба энэ нь өмнөх үнэлгээний 16 хувь гэсэн үзүүлэлтээс огцом өссөнийг харуулж байна. Түүнчлэн эрүүл мэндийн үйлчилгээний ачаалал болон боловсролын үйлчилгээний ачааллыг

бүртгэсэн хэсгүүдийн тоо буурсан байна. Энэ удаагийн үнэлгээний тоон мэдээллээс харвал өмнөх үнэлгээгээр 23 хувь байсан эрүүл мэндийн үйлчилгээний ачаалал нэрлэсэн бэрхшээл нь 16 хувь хүрч буурсан бол боловсролын үйлчилгээний ачаалал 16 хувиас 6 хувь руу буурсан байна.

График 16. Иргэдэд хүртээмжгүй байгаа үндсэн үйлчилгээ болон дэд бүтэц (эзлэх хувь)



Хүснэгт 4. Орлогоо нэмэгдүүлэх боломж бололцоо дутмаг гэсэн асуудал хамгийн их бүртгэгдсэн хороод

|                      |                      |                      |
|----------------------|----------------------|----------------------|
| Нийт<br>28 хэсэг     | 1-р хороо<br>7 хэсэг | 4-р хороо<br>7 хэсэг |
| 5-р хороо<br>7 хэсэг | 3-р хороо<br>4 хэсэг | 2-р хороо<br>3 хэсэг |

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй үндсэн асуудлаар тусгайлан боловсролын үйлчилгээний барилга байгууламжийн дутмаг байдлыг хэсгүүдийн 28 хувь мэдээлсэн бол араас

нь тусгайлан тээврийн үйлчилгээ болон нийтийн эзэмшлийн зам, талбай, барилга байгууламжид аюулгүй нэвтрэхэд шаардлагатай дэд бүтцийн дутмаг байдлыг (тус бүр 26 хувь), нэрлэжээ.

График 17. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй асуудлууд (эзлэх хувь)



## ДҮГНЭЛТ



Багануур дүүргийн хэмжээнд хийсэн энэ удаагийн үнэлгээгээр иргэдэд хамгийн хүндрэлтэй, хүрэлцээ багатай дэд бүтцээр орлогоо нэмэгдүүлэх боломж бололцоо байсан бол өмнөх үнэлгээгээр ч мөн энэ бэрхшээл зонхилж байжээ. Энэ асуудал нь хүнсний аюулгүй байдалд мэдэгдэхүйц сөрөг нөлөөлөл үзүүлж байгааг үнэлгээний үр дүн харуулсан байна. Хэсгүүдийн тал нь хүнсний хэрэглээгээ тогтмол байдлаар бууруулах үзэгдэл багасах хандлагатай байгааг мэдээлсэн ч эдгээр хэсгүүдийн дийлэнх нь

орлогоо нэмэгдүүлэх боломж бололцоо дутмаг байна гэж мэдээлсэн байна. Түүнчлэн орлогоо нэмэгдүүлэх боломж бололцоо дутмаг байх нь дүүргээс явах үндсэн шалтгааны нэг болж байна. Тиймээс эдгээр сорилтуудад шийдэл олох зорилгоор хөдөлмөр эрхлэх болон орлогоо нэмэгдүүлэх боломж бололцооны дутмаг байдлын шалтгаан, эдгээрийн шилжилт хөдөлгөөний чиг хандлага болон шилжин суурьшигчийн сайн сайхан байдалд үзүүлэх нөлөөллийг дэлгэрэнгүй судалж үзэх нь зүйтэй.




© Javkhantugs

Уг тайлангийн үр дүн, дүгнэлт нь зөвхөн судалгааны багийн байр суурийг илэрхийлэх бөгөөд ОУШХБ, түүний гишүүн улсууд, Швейцарын хөгжлийн агентлаг болон бусад хандивлагчдын байр суурийг илэрхийлэхгүй болно. Тайлангийн туршид ашигласан тэмдэглэгээ болон материалын танилцуулга нь аливаа улс орон, нутаг дэвсгэр, хот, бүс нутгийн эрх зүйн байдлын талаар ОУШХБ-ын зүгээс ямар нэгэн үзэл бодлоо илэрхийлэх, эсхүл түүний эрх баригчид, хил хязгаарыг илэрхийлээгүй болно.

ОУШХБ нь шилжин суурьшигчид, хөдөлгөөнт хүн ам болон нийгэмд тустай, хүмүүнлэг, цэгцтэй шилжилт хөдөлгөөний зарчмыг баримтлан ажилладаг. ОУШХБ нь засгийн газар хоорондын байгууллага, олон улсын хамтын нийгэмлэгийн түншүүдтэйгээ шилжилт хөдөлгөөний үйл явц дахь сорилтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, шилжилт хөдөлгөөний асуудлын талаар мэдлэг мэдээллээ дээшлүүлэх, шилжилт хөдөлгөөнөөр дамжуулан нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих, мөн шилжин суурьшигчдын нэр төр, сайн сайхныг

дээдлэх зэрэг зорилтын хүрээнд хамтран ажилладаг.

Энэхүү тайлан нь Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэйгээр, ОУШХБ-аас хэрэгжүүлж буй “Монгол Улс дахь дотоод шилжилт хөдөлгөөнийг ойлгож, удирдах нь” төслийн хүрээнд хийгдэж буй ажлуудаас гаргаж буй үр дүнгийн нэг хэсэг юм. Энэхүү төслийн зорилго нь Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицыг (ДТМ) ашиглан Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөн, хөгжлийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх замаар нотолгоонд суурилсан томъёолол, хэрэгжилтийг бэхжүүлэн бататгахад оршино. Тайланг загварчлах ажлыг Ямэй Дү, дотоодын зөвлөх Ганбатын Гэрэлтогтохын хамт боловсруулсан болно. Судалгааны асуулгын загварчлалыг ОУШХБ-ын ДТМ-ын баг, НЗДТГ-ын оролцоотойгоор боловсруулсан байна. Судалгааны мэдээллийг ОУШХБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн алба болон Глобал ДТМ-ыг дэмжих багийн техникийн дэмжлэгтэйгээр Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицын (ДТМ) хэрэглүүрийг ашиглан цуглуулж, дүн шинжилгээ хийсэн болно.



Swiss Agency for Development and Cooperation SDC  
Швейцарын хөгжлийн агентлаг